


БАТЛАВ
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ПҮРЭВСҮРЭН
2025 оны 02 дугаар сарын 26.

“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 02 дугаар сарын 26

Дугаар 04

Налайх дүүрэг

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 14:30 цагт Налайх дүүрэг 3 дугаар хороо, паркийн гүйцэтгэх захирлын өрөөнд болно.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/	Асуудал танилцуулах албан тушаалтан	Гарах шийдвэр
1	Хурлын ухаалаг дэлгэц болон бусад тоног төхөөрөмж худалдан авах тухай	30	Зөвлөлийн дарга	Тэмдэглэл

НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.02.26

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах зөвлөлийн хурлыг газрын даргын өрөөнд 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 14:30 цагт эхэлж 15:00 цагт дуусгав. Хуралд өмч хамгаалах зөвлөлийн дарга Н.Пүрэвсүрэн гишүүд Э.Энгүүн, О.Чулуун-Эрдэнэ, Г.Ганцэцэг нар болон нярав Э.Ундармаа нар оролцов. Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Хурлын ухаалаг дэлгэц болон бусад тоног төхөөрөмж худалдан авах тухай

СОНССОН НЬ: Байгууллагын дотоод хэрэгцээнд үндэслэн хурлын ухаалаг дэлгэц, зөөврийн компьютер, таблет худалдан авах шаардлага үүсээд байна.

Н.Пүрэвсүрэн: Өдрийн мэнд, манайд одоо байгаа проектор, дэлгэц 2 нь 2014 онд Улаанбаатар бизнес хөгжлийн төвөөс шилжиж ирсэн, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгө байгаа. Одоо шинээр хурлын өрөө тохижуулж байгаатай холбогдуулан ухаалаг дэлгэц, зөөврийн компьютер шинээр худалдан авах хэрэгтэй гэж үзэж байна.

Г.Ганцэцэг: Зөөврийн компьютер нь мөн нугасаараа салсан, проекторны өнгө хувирч гардаг зэрэг асуудалтай тул шинийг авах нь зөв. Бүтээгдэхүүний болон үнийн судалгааг Маркетингийн мэргэжилтэн Э.Энгүүн хийсэн байгаа. Та бүхэн судалгаатай танилцаад саналаа өгөөрэй.

Э.Энгүүн: Монголд үйл ажиллагаа явуулдаг цахилгаан бараа болон технологийн 9 их дэлгүүрийн бүтээгдэхүүн болон үнийг судалсан. Хамгийн хямд нь 10 саяаас эхлээд 21 сая хүртэлх үнэтэй ухаалаг дэлгэцүүд байна. Энэ нь хөл болон бусад дагалдах хэрэгслүүд нь багтсан үнэ байгаа. Мөн өөр дээрээ камертай, камергүй, микрофонтой, микрофонгүй гээд тухайн бүтээгдэхүүний үзүүлэлтүүд нь өөр өөр байгаа.

Мөн зөөврийн компьютерийг Dell брэндийн i7, 512GB –ийн үзүүлэлттэйг авъя гэж судалсан.

О.Чулуун-Эрдэнэ: Ер нь бол өөр дээрээ камертай, микрофонтой дэлгэц авсан нь дээр. Тэгэхгүй бол Zoom хурал хийхэд тусдаа камер, микрофон залгах шаардлага гарна. Энгийн хурлын камер л гэхэд 500,000-с дээш үнэтэй байдаг. Мөн нэгэнт авч байгаагийнх 86 инчийн том дэлгэц нь зүгээр. Дээр хурлын өрөөний урт нь 12 метр, нэлээн том өрөө байгаа тул 86с доош инч бол багадна гэж үзэж байна.

Г.Ганцэцэг: Миний бодлоор үнэ болон үзүүлэлт нь IT zone – ий StarBoard брэндийн дэлгэцийг сонгох саналтай байна. Өөр саналтай хүн байна уу?

Бүгд: Дэмжиж байна.

Г.Ганцэцэг: Эдгээрээс гадна Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан менежер Н.Ганзориг таблет авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Нэгэнт ITzone-с худалдан авалт хийж байгаа тул энэ дэлгүүрээсээ таблет болон зөөврийн компьютерээ сонгоё.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. IT zone дэлгүүрээс

- Ухаалаг дэлгэц – 8,234,910

- Хөл – 719,910

- Зөөврийн компьютер – 2,699,010

- Таблет – 2,429,100

Нийт – 14,082,930 төгрөгийн бүтээгдэхүүн худалдан авахаар шийдвэрлэв.

2. Тус хөрөнгийг хүлээн авч байгууллагын холбогдох дансанд бүртгэн авахыг
Нярав Э.Ундармаад үүрэг болгов.

Тооллогын комиссын

Дарга

Н.Пүрэвсүрэн /Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга/

Гишүүд

Э.Энгүүн /Маркетингийн мэргэжилтэн/

О.Чулуун-Эрдэнэ /Гадаад харилцаа, хамтын
ажиллагааны мэргэжилтэн/

Г.Ганцэцэг /Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга/

Э.Ундармаа /Нярав/

